



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот


Сонгинохайрхан дүүргийн 176 дугаар цэцэрлэгийн балансаас хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан 5,100,000 /таван сая нэг зуун мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эд хөрөнгийг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Сонгинохайрхан дүүргийн 176 дугаар цэцэрлэг /Ц.Цэндсүрэн/-т зөвшөөрсүгэй.


2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар /Д.Төмөрбаатар/ -т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сонгинохайрхан дүүргийн 176 дугаар цэцэрлэг /Ц.Цэндсүрэн/, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар /Д.Төмөрбаатар/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс /Д.Итгэл/-т тус тус үүрэг болгосугай.



11505700017

Нийслэлийн Эмчийн харилцааны газрын даргын
2019 оны 03 сарын 01 өдрийн
А/29 тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: СХД-ийн 176 дугаар цэцэрлэгээс СХД-ийн Засаг даргын Тамгын газарт

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
						Нэгжийн үнэ	Нийт үнэ			
1	Гэр	иж бүрэн	2014.10.23	ш	2	2,550,000	5,100,000	2,216,344.9	2,883,655.1	Шилжүүлэх
Нийт хөрөнгийн дүн							5,100,000	2,216,344.9	2,883,655.1	